



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 766

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1,3 дахь хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Өвөрхангай-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 11,121,600.00 (арван нэгэн сая нэг зуун хорин нэгэн мянга зургаан зуу) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. "Өвөрхангай-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирлыг түр хавсран гүйцэтгэгч Б.Батбаярт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг данснаас хасах ажлыг зохион байгуулах;

2.2. Хавсралтад заасан хөрөнгийг эргэлтийн хөрөнгөд сэлбэг хэрэгслээр бүртгэх ажлыг зохион байгуулах;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс /Д.Нарангэрэл/-г үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

13201975

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2020 оны 12 дугаар сарын 28-ны
өдрийн 766 дугаар тогтоолын хавсралт

**"Өвөрхангай-АЗЗА" ТӨХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй
данснаас хасах сэлбэгээр орлогод авах хөрөнгийн жагсаалт**

д/д	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн ашиглалтад орсон он	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл /төгрөг/
1	Асфальтбетон завод	1989	11,121,600.00
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		11,121,600.00 (арван нэгэн сая нэг зуун хорин нэгэн мянга зургаан зуу)